

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨВСГӨЛ УС СУВАГ ХХК-ИЙН “УХААЛАГ ХУДАГ”
ТӨСӨЛ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖИЖ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2021/120-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2021 он

Дарга, тэргүүлэх аудитор О.Ганболд	
Утас: 99382500	Цахим хаяг: ganboldo@audit.gov.mn
Аудитын менежер Э.Бат-Эрдэнэ	
Утас: 99900662	Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор Д.Отгонбаяр	
Утас: 89306788	Цахим хаяг: otgonbayar.de@audit.gov.mn
Аудитор С.Гансүх	
Утас :95908400	Цахим хаяг: gansukh.sa@audit.gov.mn
Аудитор Л.Мандахнаран	
Утас:92118277	Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn
Аудитор Г.Ичинхорлоо	
Утас: 88688168	Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
khuvsgul.audit.mn/state/16 цахим хуудаснаас авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/17

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2018 оны А/207 “Эрх үүрэг шилжүүлэх тухай” дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөвсгөл Ус суваг ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Хөвсгөл Ус суваг ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Хөвсгөл Ус суваг ХХК-ийн гүйцэтгэх захирал нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Хөвсгөл Ус суваг ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дээрх байгууллагын дарга, захирал нарт зөвлөсүгэй.
4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Д.Отгонбаяр/-т үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга, аудитын менежер /Э.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.
6. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2021 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Д.Отгонбаяр/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

О.ГАНБОЛД



Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторов 2021 оны 11 дүгээр сарын 02-ны
өдрийн 9/17 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Зөрчлийн товч утга	Зөрчил хариуцах	
		Байгууллага	Албан тушаалтан
1	Төлбөрийн акт: “Хөвсгөл ус суваг” ХХК нь 2019-2020 онд нийтийн халуун ус, дулаан хангамж, бусад туслах үйл ажиллагаанд үйлдвэр үйлчилгээний зориулалтаар 24,264 м3 ус ашигласны төлбөр болох 2,198,318 төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.	“Хөвсгөл ус суваг” ХХК	Дарга Г.Мөнхтулга
2	Албан шаардлага: “Хөвсгөл ус суваг ХХК нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд авлага, өр төлбөрийн дүнг тусгахдаа харилцагч байгууллага, иргэдтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй байна	“Хөвсгөл ус суваг” ХХК	Гүйцэтгэх захирал П.Лхагважав Ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхзул

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь Төрийн
аудитын газар

Тэргүүлэх аудитор
О. Ганболд

Аудитын менежер
Э.Бат-эрдэнэ

Ахлах аудитор
Д.Отгонбаяр

Аудитор
С.Гансүх
Л.Мандахнаран
Г.Ичинхорлоо

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3 давхар

Цахим хаяг:
audit.mn/?page_id=579

2021 оны 10 дугаар сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

**Бүлэг 1. Компанийн үйл ажиллагааны үр
дүн зорилтот түвшиндээ хүрээгүй байна.**

**1.1 Компанийн зорилтот түвшний
орлого зардлын уялдаагүй,
алдагдалтай ажилласан байна**

**1.2 1.2 Компанийн ТУЗ-ийн үйл
ажиллагаа үр нөлөөгүй байна.**

**1.3 Нийтийн халуун усны үйл ажиллагаа
үр ашиггүй байна.**

**Бүлэг 2. Компанийн хөрөнгийн орлого,
зарцуулалтад тавих хяналт сул байна.**

**2.1 Компанийн нягтлан бодох бүртгэл,
тайлагнал алдаатай байна.**

**2.2 Компанийн дотоод хяналт үр
нөлөөгүй байна**

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Хавсралт

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ХО	Хөрөнгө оруулалт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭХЯ	Эрчим хүчний яам
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
АМХГ	Аймгийн мэргэжлийн хяналтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2020 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” А/15 дугаар тушаал, 2021 оны “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/27 дугаар тушаал, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/28 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг Хөвсгөл аймгийн ИТХ, Хөвсгөл ус суваг ХХК-ийн ТУЗ, Хөвсгөл ус суваг ХХК-ийн гүйцэтгэх удирдлагад танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.

Үүнд:

- Компанийн үйл ажиллагаа үр дүнтэй явагдсан эсэх
- Санхүүгийн нөөцийг хэмнэлттэй зарцуулсан эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны хүрээнд удирдлага, бүтэц зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагаа, үйлдвэрийн үйл ажиллагаа, хөрөнгийн ашиглалт, дотоод хяналт, Төсвийн хөрөнгийн зарцуулалт болон холбогдох баримт материалыг хамруулав.

Аудитын явцад “Хөвсгөл ус суваг” ХХК-аас ирүүлсэн судалгаа, ТУЗ-ын болон гүйцэтгэх захирлын тогтоол, шийдвэр, ажлын баримт, холбогдох албан тушаалтантай ярилцлага явуулсны дүнд ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үзлээ.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу хэрэгжүүлсэн горим, сорилыг үнэлж тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020, “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020, “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУЕА-ын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитад хамрагдсан байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, тайланг судалж, нотлох зүйлсийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан нягтлан шалгах, харьцуулалт, дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглав.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу хэрэгжүүлсэн горим, сорилыг үнэлж тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХА тухай хууль
- ААНОАТ-ын тухай хууль
- НӨАТ-ын тухай хууль
- Усны тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль
- Улсын бүртгэлийн тухай хууль
- Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол, ТУЗ-ийн тогтоол болон бусад тогтоол шийдвэрүүд
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоол, шийдвэр
- Дээрх хууль, эрх зүйн актуудтай нийцүүлэн гаргасан гаргасан дүрэм, журам, норм норматив, стандарт, холбогдох бусад шийдвэр.
- Хөвсгөл ус суваг ХХК-ийн дүрэм
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 1 сарын 20-ний өдрийн 02 тоот тогтоол “Орон нутгийн өмчит компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны нийтлэг журам
- Бусад хууль, эрх зүйн актууд

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор О.Ганболд удирдаж, аудитын менежер Э.Бат-эрдэнэ үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу ахлах аудитор Д.Отгонбаяр, аудитор С.Гансүх, Л.Мандахнаран, Г.Ичинхорлоо нар 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 2021 оны 10 дугаар сарын 11-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

Аудитыг гүйцэтгэхэд тулгарсан хүндрэл бэрхшээл

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 вирусийн халдвар болон өвчлөл нэмэгдсэнтэй холбоотой компанийн ажилтнууд болон иргэдтэй уулзах, хэрэглэгчдээс санал асуулга авахад хязгаарлалттай байлаа. Мөн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогчид 2021 онд томилогдсон тул аудитын хамрах хугацаанд ажиллаагүй, эдийн засагч нь жирэмсний амралттай байсан нь мэдээлэл авахад хүндрэлтэй байсан.

Ерөнхий мэдээлэл

Хөвсгөл аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний байгууллага буюу одоогийн “Хөвсгөл Ус суваг” ХХК нь анх 1931 онд Артель нэртэйгээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба 1972 онд Нийтийн ахуйн үйлчилгээний удирдах газар, 1993 оноос Ус суваг нийтийн аж ахуйн компани, 2016 оноос “Хөвсгөл Ус суваг” ХХК /Цаашид компани гэх/ нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 11 дүгээр хуралдаанаар “Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийг татан

буулгах, шинээр аж ахуйн нэгж байгуулах” тухай хэлэлцэж, Хөвсгөл Ус Чандмань ОНӨҮГ, УСНААК ОНӨҮГ, Хөвсгөл Дулаан ХХК-ыг нэгтгэхээр шийдвэрлэж, 2016 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 56 тоот тогтоолоор “Хөвсгөл Ус суваг” ХХК-ийг байгуулах шийдвэр гарсан байна.

Компани нь 2016 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлэн 1 гишүүнтэй, хугацаагүйгээр үйл ажиллагаагаа явуулах эрх авсан байна. Компанийн хувьцаа эзэмшигч нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал байна. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,750,882 мянган төгрөгөөр тогтоож нэг бүр нь 1.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,750,882 ширхэг энгийн хувьцаа гаргасан байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор Компанийн дүрмийг шинэчлэн баталж хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 3,303,458,8 мянган төгрөгөөр тогтоожээ.

Компанийн эрхэм зорилго: Хэрэглэгчдийн унд ахуйн цэвэр ус, дулааныг горимын дагуу түгээх, усыг татан зайлуулах, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэн, нийтийн үйлчилгээг соёлч шуурхай хүргэж санхүүгийн хувьд бүрэн биеэ дааж ажиллахад оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

- Ус цуглуулах, ариутгах, ус хангамж, ус түгээх
- Бохир ус татан зайлуулах, цэвэрлэх
- Дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах
- Нийтийн аж ахуйн ажил, үйлчилгээ эрхлэх

Тус компани нь 2020 оны байдлаар 202 аж ахуйн нэгж, байгууллага, 45 орон сууц, 504 хувийн орон сууцны нийт 1831 айл өрхийг унд ахуйн цэвэр усаар хангаж, бохир усыг татан зайлуулж, цэвэрлэн байгальд нийлүүлэх үйлчилгээ үзүүлсэн байна. Компанийн эдийн засгийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 /мян.төг/

Үзүүлэлт	Нийт орлого	Нийт зардал	Ашиг/алдагдал
2019 он	1,978,718.0	1,972,140.0	6,578.0
2020 он	2,110,788.7	2,125,297.1	-14,508.6

Аудитын хамрах хугацаанд компанийн гүйцэтгэх захирлаар Г.Энхбаяр, Д.Сүхээ, ерөнхий нягтлан бодогчоор Х.Болд-Эрдэнэ нар ажиллаж байсан. Компанийн ТУЗ-ийн 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 20 дугаар тогтоолоор гүйцэтгэх захирал Г.Энхбаярыг чөлөөлж, 21 дүгээр тогтоолоор ерөнхий инженер Д.Сүхээг гүйцэтгэх захирлын үүргийг хавсран гүйцэтгэгчээр томилсон байна. ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 08 ны өдрийн 12 дугаар тогтоолоор П.Лхагважавыг гүйцэтгэх захирлаар томилсон байна. Гүйцэтгэх захирлын 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн Б/40 Х.Болд-Эрдэнийг ерөнхий нягтлан бодогчоос чөлөөлж 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн Б/41 дүгээр тушаалаар Б.Мөнхзулыг томилсон байна.

БҮЛЭГ 1: Компанийн үйл ажиллагаа зорилтот түвшиндээ хүрээгүй байна.

1.1 Компанийн зорилтот түвшний орлого зардлын уялдаагүй, алдагдалтай ажилласан байна

1.1.1 Бизнес төлөвлөгөөг үр нөлөөтэй байхаар боловсруулаагүй байна.

“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн гүйцэтгэх захирал нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг нь хангах эрх, үүрэгтэй. ТУЗ-ийн баталсан 2019-2020 оны зорилтот түвшнийг дараах байдалтай баталсан байна. *Хүснэгт №2*

№	Тайлант он	Орлого /мян.төг/	Зардал /мян.төг/	Ашиг /мян.төг/	ТУЗ-ын тогтоолын дугаар , огноо
1	2019	2,055,652.9	2,053,108.0	2,544.9	2019 оны 1 дүгээр сарын 29-ны өдрийн 02 тоот тогтоол
2	2019 /тодотгол/	1,978,718.1	1,971,409.2	7,308.9	2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 24 тоот
3	2020	2,228,738.8	2,228,674.0	64.8	2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 3 тоот тогтоол

Компанийн бизнес төлөвлөгөөг өртгийн төв¹-өөр орлогыг төлөвлөсөн боловч зардлыг уялдуулаагүй, өртгийн төв бүрээр зардал, ашиг, алдагдлыг тооцож төлөвлөөгүй байна. */Хавсралт 1, 2-оос харна уу/.*

Тухайлбал: Халаалтын орлогын тооцоог төлөвлөсөн боловч халаалттай холбоотой гарах зардлын тооцоо хийгээгүй, түүнээс хир хэмжээний ашиг олох, алдагдал хүлээхийг тухайлан тооцож төлөвлөөгүй байна.

Бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа эрсдэлийг үнэлээгүй, үйлдвэрлэл, борлуулалт, удирдлагын зардлыг тус бүрд нь салгаж тооцоогүйгээс бизнес төлөвлөгөөний үр нөлөөг бууруулсан байна.

1.1.2 Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг багаар тооцоолсноор зардал, алдагдлыг хэмжээг бууруулан тайлагнасан байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлт

“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн нийт орлогын гүйцэтгэл 2019 онд 1,978,718.1 мянган төгрөг болж 2019 оны зорилтот түвшин 2,055,653.9 мянган төгрөгөөс 76,935.8 мянган төгрөгөөр бага буюу 96.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Компанийн нийт орлогын гүйцэтгэл 2020 онд 2,110,788.7 мянган төгрөг болж 2019 оны гүйцэтгэлээс 132,070.6 мянган төгрөгөөр өссөн боловч зорилтот түвшнээс 117,950.1 мянган төгрөгөөр бага буюу 94.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. /Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, гүйцэтгэлийг хавсралт 1-ээс харна уу/

Орлогын ихэнх хувийг цэвэр, бохир ус, халаалт, халуун ус, гэр хорооллын усан хангамжийн орлого бүрдүүлсэн байна.

Компанийн 2019-2020 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг ТУЗ-д танилцуулахдаа үйлдвэрлэлийн зардал, удирдлагын зардлыг

¹ Компани нь цэвэр ус, бохир ус, зөөврийн цэвэр ус, зөөврийн бохир ус, халаалт, халуун ус, худаг, усан сан, түрээс, шинэ холболт, засвар үйлчилгээ, усны тоолуурын үйлчилгээ гэсэн өртгийн төвүүдтэй.

салгаагүй, зардлын зорилтот түвшний хэрэгжилтийг эдийн засгийн нийт үзүүлэлтээр гаргасан байна.

Компанийн ерөнхий журналд орлого, зардлыг өртгийн төв бүрд хуваарилан бүртгэсэн боловч 2020 оны санхүүгийн тайлангаарх орлогын гүйцэтгэл 2,110,788.8 мянган төгрөг, ТУЗ-д хүргүүлсэн орлогын гүйцэтгэл 2,068,850.8 мянган төгрөгөөс 41,938.0 мянган төгрөгөөр их, орлогын нэр төрлийг хольж бүртгэснээс өртгийн төв бүрийн орлогын дүн, борлуулалтын журнал дахь дүнгээс зөрүүтэй байна.

Ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор 2020 онд аймгийн онцгой комиссын шийдвэрээр хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарласан нь борлуулалтын төлөвлөгөө 117,950.1 мянган төгрөгөөр буюу 5.3 хувиар тасрах гол шалтгаан болжээ. Тухайлбал: Халуун усны үйл ажиллагааг хязгаарласнаас халуун усны орлогын төлөвлөгөө 238,359.0 мянган төгрөг байснаас 48.2 хувь буюу 114,814.8 мянган төгрөгөөр дутуу биелсэн байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: *Хүснэгт №3 /мян.төг/*

Үзүүлэлт	2019 он төлөвлөгөө	2019 он Гүйцэтгэл	2020 он Төлөвлөгөө	2020 он Гүйцэтгэл	2020 оны гүйцэтгэл 2019 оноос	2019 оны биелэлт хувиар	2020 оны биелэлт хувиар
Нийт орлого	2,055,653.9	1,978,718.1	2,228,738.8	2,110,788.7	132,070.6	96.3	94.7
Нийт зардал	2,049,688.1	1,971,409.2	2,228,674.0	2,125,296.7	153,887.5	96.2	95.4
Ашиг /алдагдал/	51,65.6	7,308.9	64.8	-14,508.0	-66,165.6		

/Эх сурвалж: 2019, 2020 оны санхүүгийн тайлан/

“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн орлогын төлөвлөгөө 2019 онд 3.7 хувь, 2020 онд 5.3 хувиар дутуу биелсэн нь ковид-19 цар тахлын нөлөөнөөс шалтгаалан харилцагч байгууллагын үйл ажиллагаа хязгаарлагдаж, төлөвлөсөн орлого буурсантай холбоотой байна.

Зардлын төлөвлөгөөний биелэлт:

Компанийн нийт зардлын гүйцэтгэл 2,125,296.7 мянган төгрөг болж өмнөх оноос 153,887.5 мянган төгрөгөөр өсөж, зорилтот түвшнээс 103,377.3 мянган төгрөгөөр бага буюу 95.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайлангаарх 2020 оны зардлын гүйцэтгэл зорилтот түвшнээс 103,377.3 мянган төгрөгөөр бага буюу 95.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцохдоо алдаатай тооцоолсны улмаас зардлыг нийт зардлыг бага, ашгийг нэмэгдүүлж тайлагнасан байна. Аудитаар үндсэн хөрөнгөөс түүвэрлэн элэгдэл тооцсон байдлыг шалгахад 18,090.6 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцоолсон байна. Хөвсгөл ус суваг ХХК-ийн зардлын бүтцийг графикаар харуулбал:




График 1: Зардлын бүтэц

Графикаас харвал материаллаг хэмжээний зардал нь цалин, НДШ-ийн зардал хамгийн их буюу нийт зардлын 61 хувь, цахилгааны зардал 7 хувь, элэгдлийн зардал 9 хувь, түлш халаалт 6 хувь, шатахууны зардал 5 хувь байна. /2020 оны байдлаар/

Компанийн борлуулалтын орлого 2020 онд зорилтот түвшнээс буурч борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал өсөж, ашиг өмнөх оноос буурсан нь Ковид-19 цар тахлын тархалтаас шалтгаалан орлого буурсан, нийтийн халуун усны үйлчилгээний алдагдал өндөр байсантай холбоотой байна. Тайлант үеийн үр дүнд элэгдлийн зардлыг бүрэн тусгаагүйгээс алдагдлыг бууруулж тайлагнасан байна.

1.2 Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

1.2.1 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагаа үр нөлөөгүй байна.

“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал /Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид/ хуульд заасан хугацаанд 2019 он, 2020 онд тус бүр 2 удаа хуралджээ.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн ТУЗ нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг баримтлан үйл ажиллагаа явуулж байна.

“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. “Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн ТУЗ нь Компанийн дүрмийн 9.21²-д заасан шалгуурын дагуу аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороог 2019 оны 05 дугаар сарын 08-ний өдрийн 4 дүгээр хурлын тогтоолоор тус бүр 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, 2020 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 15, 16, 17 дугаар тогтоолуудаар хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан байна. ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүд нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8³, 79 дүгээр зүйлийн 79.1.3⁴, 79.1.4⁵-д заасан шалгуурыг тус тус хангаж байна. Компанийн ТУЗ нь холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэмд заасан эрх хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2019

² Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна. Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

³ Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна

⁴ төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй

⁵ компанитай бизнесийн аливаа холбоогүй

онд 24 тогтоол, 2020 онд 9 удаагийн хурлаар 27 тогтоол гарган ажиллажээ. “Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн ТУЗ нь 2019-2020 онд компанийн бүтэц орон тоо, бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон хөдөлмөрийн дотоод журам, “Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн 2017-2020 оны хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг баталжээ. Аудитаар ТУЗ-ын дэргэдэх хороодын үйл ажиллагааг хянаж үзэхэд аудитын хороо нь чиг үүргийн дагуу тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

ТУЗ-ийн гишүүд нь компанийн ашигт ажиллагааг сайжруулах, дотоод хяналтыг үр ашигтай зохион байгуулах талаар бодитой санал, санаачилга гаргаж ажиллаагүй байна. Тухайлбал: ТУЗ-ийн 2019 оны 12 сарын 20-ны өдрийн 23 дугаар тогтоолоор өөрийн хөрөнгөөр Мөрөн сумын 210 жилийн ойд зориулсан ном худалдан авахад 10,000.0 мянган төгрөг, эрүүл мэндийн хашаан дахь эм хангамжийн барилгын халаалтын шугам засвар хийхэд 4,749.3 мянган төгрөг, Уран дөш зуслангийн халуун усны засварт 5,104.9 мянган төгрөг, нийтийн ногоон байгууламжийн засвар 2,000.0 мянган төгрөг нийт 29,379.3 мянган төгрөгийг зарцуулах шийдвэр гаргасан байна. Энэ зардал нь компанийн үйл ажиллагаатай холбоогүй, компанид үр ашиггүй шийдвэр болсон байна.

ТУЗ нь 2019-2020 онд гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг улирал бүр гаргаагүй байна.

1.2.2 Компанийн ерөнхий нягтлан бодогч нь хууль, дүрэмд заасан албан тушаалын шалгуурыг хангаагүй байна.

“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 1 тоот тогтоолоор 2019 оны орон тоог 162, 2020 оны 1 дүгээр сарын 23-ний өдрийн 4 тоот тогтоолоор 2020 оны орон тоог 167 байхаар баталсан байна.

Ухаалаг худгийн үйл ажиллагаа эхэлсэн болон 2 халуун усны үйл ажиллагаа зогссонтой холбогдуулан 2021 онд батлагдсан орон тоо өмнөх оноос 16-аар буурсан байна. Компанийн бүтэц зохион байгуулалтыг схемээр харуулбал: Схем 1

“ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Компани нь 2019-2020 онд батлагдсан орон тооны хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Аудитаар ажилчдын хувийн хэрэг, албан тушаалын тодорхойлолтыг түүвэрлэн хянаж үзэхэд инженер техникийн ажилтнууд нь тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж байгаа ч дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- “Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын дагуу шинэчлэн баталгаажуулаагүй байна.
- Ерөнхий нягтлан бодогч нь ТБӨТХ-н 69 дүгээр зүйлийн 69.3⁶, компанийн дүрмийн 10.8⁷-д заасан шалгуурыг хангахгүй байна.

1.3 Нийтийн халуун усны үйл ажиллагааны алдагдал нь компанийн нийт алдагдлын 96 хувийг эзэлж байна.

1.3.1 Үйл ажиллагаа явуулахад шаардлагатай тусгай зөвшөөрлүүд нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байна.

Хөвсгөл ус суваг ХХК нь эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр нийт 6 тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг эзэмшиж байна. Үүнээс ус ашиглах эрхийн бичгийн хугацаа дууссан байна. Хөвсгөл ус суваг ХХК-ийн ашиглаж буй тусгай зөвшөөрөл эрхийн бичгийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4

№	Тусгай зөвшөөрлийн нэр	Олгосон эрх бүхий байгууллага	Хүчинтэй хугацаа	Зохицуулах хууль эрх зүйн акт
1	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг ашиглах	ХСУХАТАУЗЗ	2022.10.30	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйл
2	Дулаан үйлдвэрлэх, түгээх зохицуулалттай хангах	Хөвсгөл аймгийн ЭХЗЗ	2024.12.10	Эрчим хүчний тухай хуулийн 11.3.1 дэх заалт
3	Химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах	Байгаль орчин аялал жуулчлалын яам	2022.08.26	Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйл
4	Ус ашиглах эрхийн бичиг	Хөвсгөл аймгийн БОАЖГ	2021.03.13	БОАЖС-ын 2018 оны А/376 дугаар тушаал
5	Ус ашиглах гэрээ	Хөвсгөл аймгийн БОАЖГ	2022.02.23	Байгаль орчин ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А-367 дугаар тушаал
6	Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа	Стандарт хэмжил зүйн газар	2025.08.31	Хэмжил зүйн тухай хуулийн 11.1 дэх заалт

Ус ашиглах эрхээс бусад тусгай зөвшөөрлүүд нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байна.

⁶ Төрийн өмчит хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч нь мэргэшсэн байх

⁷ Ерөнхий нягтлан бодогч нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан мэргэшсэн нягтлан бодогч байна.

1.3.2 Мөрөн хотын ундны усны эх үүсвэрийн худгуудад цахилгааны нөөц эх үүсвэр шаардлагатай байна.

Хөвсгөл ус суваг ХХК нь цэвэр ус түгээх үйл ажиллагаанд дараах тоног төхөөрөмж, барилга, байгууламжуудыг ашиглаж байна. Үүнд:

Эх үүсвэрийн худаг

Усны эх үүсвэрийн 5 худаг нь улсын онцгой объект бөгөөд 24 цагийн турш худгийн операторууд ажилладаг.

Эдгээр худгууд нь хоногт дунджаар 1000 м.куб ус гарган ажиллаж байна. Төвийн цахилгаан эрчим хүч тасарсан нөхцөлд нөөцийн цахилгааны эх үүсвэргүй байгаа нь өвлийн улиралд цэвэр усны шугам сүлжээ хөлдөх эрсдэлийг үүсгэж байна.

Цэвэр усны 2 дугаар өргөгч насос станц

Уг станц нь 2000 онд ашиглалтад орсон Мөрөн хотын цэвэр усны төвийн шугамд холбогдсон бүх хэрэглэгчдэд ус түгээх үүрэгтэй. Цэвэр усны 2 дугаар өргөгч насос станц нь 450 м.куб багтаамжтай. Уг хүчин чадал нь Мөрөн хотын одоогийн хэрэгцээг хангаж байгаа боловч хэрэглэгчийн тоо, ачаалал нэмэгдэх эрсдэлийг тооцож цаашид станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлого барих нь зүйтэй байна.

Гүний худаг

Мөрөн хотын гэр хорооллын айл өрхүүдийн ундны усны хэрэгцээг хангах 19 худаг үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 15 худаг ухаалаг системээр тоноглогдсон 24 цагийн ажиллагаатай байна. Худгийн барилга байгууламжууд нь хуучирч муудсан тул урсгал засвар хийх шаардлагатай 11 худаг, их засвар хийх шаардлагатай 6 худгийн барилга, буулгаж шинээр барих шаардлагатай 2 худгийн барилга байна. Худаг болон усан сангийн цахилгааны эх үүсвэр болон насос, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа хэвийн байна.

Усан сан



Мөрөн хотын гэр хорооллын айл өрхүүдийн ундны усны хэрэгцээг хангах 32 усан сан үйл ажиллагаа явуулж байна. Усан сангуудын барилга байгууламжуудын шинэчлэл 2019 оноос эхэлж 6 усан сангийн барилгыг шинээр барьсан байна. Бусад усан сангийн барилгуудад урсгал засвар хийх шаардлагатай. Ус нөөцлөх савыг шинэчлэх шаардлагатай 20 усан сан байна.

Ус зөөврийн машин

Усан сангуудыг цэвэр усаар хангах зориулалтаар 5 тонн даацтай 3 ус зөөврийн машиныг ашиглаж байна. Эдгээр машинуудыг 2013 он, 2014 оноос ашиглаж эхэлсэн. Машинуудын ерөнхий чанар байдал муудсан ажлын ачаалал өндөр байдаг тул цаашид ус зөөврийн машинуудыг шинэчлэх болон тоо ширхэг, хүчин чадлыг нэмэх шаардлагатай байна.

Хөвсгөл ус суваг ХХК нь ариутгах татуургын үйл ажиллагаанд дараах тоног төхөөрөмж, барилга байгууламжуудыг ашиглаж байна. Үүнд:

Цэвэрлэх байгууламж

Мөрөн хотын бохир усыг цэвэрлэх 2 байгууламж ажиллаж байна. Анхны цэвэрлэх байгууламж нь 2000 онд ашиглалтад орсон хоногт 1000 м.куб бохир усыг хүлээн авах хүчин чадалтай шороон байгууламж байна.

Шинэ цэвэрлэх байгууламж нь 2021 онд ашиглалтад орсон хоногт 3000 м.куб бохир усыг хүлээн авах чадалтай бүрэн биологи цэвэрлэгээтэй цэвэрлэх байгууламж байна. Одоогийн байдлаар хоногт дунджаар 700-800 м.куб бохир ус хүлээн авч байна.



Бохир усны насост станц

Бохир усны 3 насост станц үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууламжуудыг 2018-2019 онд өргөтгөж шинэчилсэн бөгөөд үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Хөвсгөл ус суваг ХХК нь жил бүр улс, орон нутгийн төсөв болон өөрийн хөрөнгөөр барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.

1.3.3 Цэвэр усны хамгаалалтын зурвас болон эрүүл ахуйн хязгаарлалтын бүс зөрчигдсөн байна.

Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2⁸ дахь заалт, Засгийн газрын 2011 оны 263 дугаар тогтоол (Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолоор хүчингүй болсон)-ын 3 дугаар хавсралт “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах

⁸ Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга шугам сүлжээг хамгаалах дүрмийн дагуу хамгаалалтын зурвасын хэмжээг баталгаажуулна.

дүрэм”-ийн 3⁹ дахь заалтын дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас тогтоон Хөвсгөл аймгийн Засаг даргаар хамгаалалтын зурвасын хэмжээг баталгаажуулахаар заасан байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/752 дугаар захирамжаар Мөрөн сумын нутаг дэвсгэр дэх инженерийн шугам сүлжээний бүсэд хамгаалалтын зурвас тогтоох тухай захирамжилсан.

Хөвсгөл ус суваг ХХК нь 2020 онд хэрэглэгчдэд 41.9 км шугам сүлжээгээр цэвэр ус, 1.1 км шугам сүлжээгээр дулаан дамжуулан түгээж, 27.0 км шугам сүлжээгээр бохир ус дамжуулан зайлуулах үйлчилгээ үзүүлж байна. Гадаад, дотоод санхүүгийн эх үүсвэрээр хуучирсан шугам сүлжээг шинээр солих ажлыг хийж байгаа боловч шугамын усны алдагдал буурахгүй байгаа нь шаардлагатай бүх шугам сүлжээг сольж чадахгүй, шугам сольсон аж ахуйн нэгжүүдийн ажлын чанар муу байгаатай холбоотой байна.

Хуучин цэвэр усны шугамыг актлах, эсвэл шинээр бүртгэх албан ёсны шийдвэргүйгээс “Хөвсгөл ус суваг” ХХК нягтлан бодох бүртгэлээс хуучин шугамаа хасаагүй, биетээр байхгүй хөрөнгө нягтлан бодох бүртгэл, тайланд туссан хэвээр байна. Энэ нь санхүүгийн тайлагналын бодитой оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн хөрөнгөд бүртгэлтэй байсан 5.1 км цэвэр усны шугамыг “Хөвсгөл дулааны станц” ТӨХК улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэн сольж Төрийн өмчийн хорооны даргын 2015 оны 3/1093 тоот албан бичгийг үндэслэн өөрийн хөрөнгөөр бүртгэн авсан байна. “Хөвсгөл ус суваг” ХХК, “Хөвсгөл дулааны станц” ТӨХК энэ шугам сүлжээг хэн эзэмших талаар маргаантай байгаа. Орон нутгийн өмчийн газар энэ талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандсан боловч одоог хүртэл шийдвэр гараагүй байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн эзэмшиж байгаа инженерийн шугамаас 0.5 км-т нь хамгаалалтын зурвас зөрчигдсөн байна. Эх үүсвэрийн 5 худаг, гүний 6 худаг, 27 усан сан эрүүл ахуйн хязгаарлалтын бүс зөрчигдсөн нөхцөлд үйл ажиллагаа явуулж байна. Эрүүл ахуйн хязгаарлалтын бүсэд 117 айл өрх амьдарч, албан газар үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь Усны тухай хууль 22.3¹⁰, Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 51/75 дугаар хамтарсан тушаалын 1-р хавсралтын 32¹¹-д заасантай нийцэхгүй байна.

1.3.4 Нийтийн халуун усны үйл ажиллагааны алдагдал нь компанийн нийт алдагдлын 96 хувийг эзэлж байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээс хамгийн их алдагдалтай нь гэр хорооллын усан сан болон халуун усны үйл ажиллагаа байна.

Халуун усны үйлчилгээг 2019 онд 71,482 хүнд үзүүлж байсан бол 2020 онд 56,217 хүнд үзүүлж 2019 оноос 15,265 хүнээр үйлчлүүлэгчдийн тоо багассан байна.

Халуун усны үйл ажиллагаанаас 2019 онд 156,439.5 мянган төгрөгийн орлого олсон бол 2020 оны орлогыг бизнес төлөвлөгөөнд 238,359.0 мянган төгрөг байхаар

⁹ Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

¹⁰ Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно.

¹¹ Хот суурин газрын төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно.

төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 123,544.2 мянган төгрөгийн орлого орж, 395,170.3 мянган төгрөгийн зардал, 271,626.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангаар хүлээсэн нийт алдагдлын 96 орчим хувийг эзэлж байна. Халуун усны үйлчилгээний орлого муу байсантай холбоотойгоор 2020 онд 2 дугаар халуун ус, 2021 онд 3 дугаар халуун усны салбарын үйл ажиллагааг зогсоож дуудлага худалдаагаар худалдсан байна. Компани нь 2021 онд 1 дүгээр халуун усны барилгад их засвар хийн шугам сүлжээг шинэчилж, үнэ тарифт өөрчлөлт оруулсан байна. Халуун усны салбаруудын санхүүгийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал: *Хүснэгт №5* мян төг

Үзүүлэлт	1 дүгээр халуун ус	2 дугаар халуун ус	3 дугаар халуун ус	Нийт дүн
Нийт орлогын дүн	81,183.1	19,075.5	23,285.6	123,544.2
Цалин	94,758.4	63,874.8	86,928.9	245,562.1
НДШ	11,843.9	8,249.0	7,341.1	27,434.0
Цахилгаан	25,720.5	2,924.7	2,332.6	30,977.8
Түлш, халаалт	58,612.0	880.0	880.0	60,372.0
Шатахуун	1,000.0			1,000.0
Сэлбэг	9,510.4	1,546.4	1,418.0	12,474.8
Засвар үйлчилгээ	1,357.8	259.8	533.8	2,151.4
Бусад	4,681.7	2,457.3	1,082.5	8,221.5
Элэгдэл	5,218.5	567.0	1,191.2	6,976.7
Нийт зардлын дүн	212,703.2	80,759.0	101,708.1	395,170.3
Нийт ашиг	- 131,520.1	- 61,683.5	- 78,422.5	- 271,626.1

Эх сурвалж: 2020 оны санхүүгийн тайлан

Халуун усны үйлчилгээний газрын борлуулалт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байгаа дараах шалтгаанууд байна. Үүнд:

- Ковид-19 цар тахлын улмаас 2020 оны 11 болон 12 саруудад халуун усны үйл ажиллагаа хязгаарлагдсан.
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн халуун усны үйлчилгээ явуулдаг салбар нэмэгдсэн.
- Халуун усны газрууд иргэдийн хүсэл сонирхолд нийцсэн чанартай үйлчилгээг үзүүлж чадахгүй байна.
- Халуун усны газруудын орлогод дотоод хяналт муу хэрэгжсэн.

Халуун усны газрын алдагдлыг багасгахын тулд борлуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах, үйлчлүүлэгчдийн сонирхлыг нэмэгдүүлэхийн тулд борлуулалт бүрд цахим төлбөрийн баримтыг хэвлэж, үйлчлүүлэгчээр шаардуулахгүй олгож хэвших, үйлчилгээний ажилтнууд олон нийтэд зөв боловсон үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2: Компанийн хөрөнгийн орлого, зарцуулалтад тавих хяналт сул байна.

2.1. Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал алдаатай байна.

2.1.1 Аймгийн ИТХ, компанийн ТУЗ-өөс гаргасан хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой зарим шийдвэрүүд нь компанийн үр ашгийг бууруулж байна.

Компанийн ТУЗ нь “Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.2¹²-д заасан чиг үүргийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2019 онд 796,404.7 мянган төгрөг, 2020 онд 721,672.4 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Аймгийн ИТХ-аас 2019-2020 онд хөрөнгө захиран зарцуулах 237,541.8 мянган төгрөгийн 2 тогтоол, ТУЗ нь 234,989.8 мянган төгрөгийн 6 тогтоол, гүйцэтгэх захирал нь хөрөнгө зарцуулах 44,457.5 мянган төгрөгийн 40 тушаал гаргасан байна. Үүнээс дараах шийдвэрүүд нь компанид үр ашиггүй байна.

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 01 тоот тогтоолоор баталсан ашиглагдахгүй болсон Хөвсгөл ус суваг ХХК-ийн эзэмшиж байсан зуухны барилгын 5 газрыг 184,745.0 мянган төгрөгөөр худалдах шийдвэрийн дагуу Орон нутгийн өмчийн газар дуудлага худалдаа зохион байгуулж, 3 газрыг борлуулж 139,700.0 мянган төгрөгийн орлого Орон нутгийн өмчийн газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Хөвсгөл ус суваг ХХК нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлага худалдааг зохион байгуулах журам”-ын 8.3.2¹³-д заасны дагуу дуудлага худалдааны орлогын 50 хувь болох 69,850.0 мянган төгрөгийг өөрийн дансанд авах боломжийг алдсан байна.
- ТУЗ-ийн 2020 оны 05 сарын 04-ний өдрийн 12 дугаар тогтоолоор Мөрөн сумын 100 жилийн ойд зориулсан ном худалдан авахад 10,000.0 мянган төгрөгийг зарцуулах шийдвэр гаргасан байна.

Компанийн ТУЗ нь Хөвсгөл ус суваг ХХК-д үр ашиггүй 10,000.0 мянган төгрөгийн 1 шийдвэр гаргасан байна.

2.1.2 Авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн санхүүгийн тайлан дахь дансны авлага 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 389,363.5 мянган төгрөг байна. Компанийн авлагын үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6 мян.төг

№	Харилцагчид	2019.12.31	2020.12.31	2021.06.30
1	НДШ авлага		1,157.9	-
2	Аж ахуй нэгж, байгууллага: Дотоод	23,270.9	22,200.7	22,339.9
3	Аж ахуй нэгж, байгууллагуудын ус дулаан	178,148.9	238,327.9	7,682.9
4	Төсөвт байгууллагуудын ус, дулаан		9,986.4	55,684.5
5	Орон сууц, айл өрхүүдийн ус, дулаан		92,814.7	63,589.7
6	Халаалт: Орон сууц		10,426.4	10,426.4
7	Хувь хүнээс авах авлага		7,621.9	7,813.7

¹² Компанийн бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, бүтэц орон тоо батлах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, сургалтын төлбөр хэмжээг тогтоох

¹³ Компани болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын эд хөрөнгийн дуудлага худалдааны орлогыг хөрөнгө худалдан авах, сэргээн засварлах, шинэчлэх зорилгоор өмч эзэмшигч байгууллагын санал, холбогдох материалыг үндэслэн худалдсан хөрөнгийн үнийн 50 хувийг тухайн байгууллагын дансанд ишлэжүүлж болно

8	Ажилчдаас авах авлага	12,215.4	11,556.7	7,502.8
9	Найдваргүй авлагын хасагдуулга		(4,729.1)	(4,729.1)
	НИЙТ АВЛАГЫН ДҮН	213,635.1	389,363.5	240,310.9

Эх сурвалж: 2019, 2020 оны санхүүгийн тайлан

Хөвсгөл ус суваг ХХК-ийн захирал нь ТУЗ-ийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу авлага барагдуулах аяныг зохион байгуулах тушаал гаргаж ажилласан боловч төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн 26 дугаар тогтоолоор нийт 59,690.2 мянган төгрөгийн өндөр насжилттай авлагыг шүүхэд шилжүүлэх шийдвэр гаргасан байна. Үүнд:

- Орон сууц халаалтын авлага 10,426.4 мянган төгрөг
- Хувь хүнээс авах авлага 7,621.9 мянган төгрөг
- Ажилчдаас авах авлага 3,139.0 мянган төгрөг
- ААН-ээс авах авлага 38,502.9 мянган төгрөг байна.

Эдгээр авлагууд нь 2016 онд Хөвсгөл ус суваг ХХК-ийг үүсгэн байгуулахад татан буулгасан УСНААК ОНӨҮГ, Хөвсгөл дулаан ХХК, Хөвсгөл ус чандмань ОНӨҮГ-ийн дансанд бүртгэлтэй байсан байна.

Өндөр насжилттай авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах цаашид борлуулалтын авлага барагдахгүй байх эрсдэлийг тооцож найдваргүй авлагын нөөцийг жил бүр тооцож ажиллах шаардлагатай байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн санхүүгийн тайлан дахь богино хугацаат өр төлбөр 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 551,268.7 мянган төгрөг байна. Компанийн богино хугацаат өр төлбөрийг хүснэгтээр харуулбал: *Хүснэгт 7 мян.төг*

№	Харилцагчид	2019.12.31	2020.12.31	2021.06.30
1	Дотоод байгууллагуудад өгөх өглөг	7,933.7	6,835.8	5,591.5
2	НӨАТ-ын өглөг		68,232.4	34,811.7
3	Ажилчдад өгөх өглөг		290.0	888.0
4	Хүүгийн өглөг: Азийн хөгжлийн банк	475,910.5	475,910.5	475,910.5
5	Татварын өглөг	1,965.1		
6	НДШ-ийн өглөг	644.2		
	НИЙТ	486,453.5	551,268.7	517,201.7

Эх сурвалж: 2019, 2020 оны санхүүгийн тайлан

Урт хугацаат зээлийн данс нийт 8,914,636.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

- Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх төслийн зээл 1,433,939.6 мянган төгрөг /2003 он/
- Нийтийн аж ахуйн байгууллагуудын автомашины парк шинэчлэлт хийх төслийн зээл 443,352.0 мянган төгрөг /2011 он/
- Шинэ цэвэрлэх байгууламж барьсан зээл 7,394,880.8 мянган төгрөг /2021 он/

Дээрх урт хугацаат зээлүүдийн эргэн төлөлт огт хийгдээгүй бөгөөд хугацаа хэтэрсэн үндсэн төлбөр 1,589,112.8 мянган төгрөг болсон байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн тайлан гаргахдаа харилцагч байгууллагатай үүссэн авлага, өглөгийг тооцоо нийлэхгүйгээс 91,597.8 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Тооцоо нийлж баталгаажуулаагүйн улмаас санхүүгийн тайланд зөрүүтэй тусгагдсан авлага, өглөгийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №8

№	Үүссэн тооцоо	Харилцагч байгууллага	Санхүүгийн тайланд тусгасан дүн	Тооцоо нийлсэн дүн	Зөрүү
1	Халаалтын тооцоо /авлага/	Хөвсгөл дулааны станц ХХК	50,856.9	32,556.2	18,300.7
2	НӨАТ-ын тооцоо /өглөг/	Татварын хэлтэс	68,232.4	73,290.7	5,058.3
4	Зээлийн хүүгийн тооцоо /өглөг/	Сангийн яамны зээл	475,910.5	544,149.7	68,238.8
	Дүн				91,597.8

Авлага, Өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгахдаа харилцагч иргэн, хуулийн этгээдтэй тооцоо нийлж баталгаажуулдаггүй, өндөр дүнтэй өр төлбөрийг барагдуулах талаар салбарын яам, аймаг орон нутгийн удирдлагуудад хандаж шийдвэрлэх арга хэмжээ аваагүй байна.

2.1.3 Гэр хороололд ухаалаг худаг төсөл амжилттай хэрэгжсэн байна.

Хөвсгөл ус суваг ХХК нь 2019-2020 онд үндсэн үйл ажиллагааны зардлаас гадна өөрийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалтын ажлын төсвийг ТУЗ-өөр батлуулж ажилласан байна.

Хөвсгөл ус суваг ХХК нь 2019 онд 26 төсөл арга хэмжээнд 798,200.0 мянган төгрөгийн тендер зарлахаас 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж 634,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Харин 2020 онд 39 төсөл арга хэмжээнд 721,672.4 мянган төгрөгийн тендер зарлахаас 533,513.3 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй 14 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж 490,096.9 мянган төгрөгийн гэрээ байгуулж санхүүжүүлсэн байна.

Өөрийн хөрөнгө оруулалтаар 2019 онд 222,000.4 мянган төгрөг, 2020 онд 185,533.6 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг нарийн судалгаа тооцоолол хийгээгүйн улмаас зарим хөрөнгө оруулалтууд хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- Дуудлагын смарт систем, цэвэр усны эх үүсвэрийг автомат удирдлагын системд шилжүүлэх ажлыг 2020 онд 30,000.0 мянган төгрөгөөр төсөвлөсөн боловч зах зээлийн өртөг нь 120,000.0 мянган төгрөг болсон тул хэрэгжих боломжгүй болсон байна.

Хөвсгөл ус суваг ХХК 2020 онд өөрийн хөрөнгөөр санхүүгийн иж бүрэн программыг 46,600.0 мянган төгрөгөөр худалдан авах төлөвлөгөөнд тусган, тендер зарлахад Смарт ложик ХХК шалгарсан. 2020 оны 04 дүгээр сард Смарт ложик ХХК-аас Smart ERP программыг 30,000.0 мянган төгрөгөөр худалдан авахаар гэрээ байгуулсан байна. Худалдан авах гэрээгээр Смарт ложик ХХК нь санхүүгийн систем, удирдлагын мэдээллийн систем, цаг бүртгэлийн систем гэсэн 3 уялдаатай системтэйгээр нэвтрүүлэх үүрэг хүлээсэн.

Одоогийн байдлаар зөвхөн санхүүгийн системийг ашиглаж байгаа ч удирдлагын мэдээллийн систем, цаг бүртгэлийн системийн холболт хийгээгүй

байна. Систем хугацаандаа бүрэн нэвтрээгүй байхад нэвтрүүлэлтийн хөлс болох 11,300.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлсэн байна.

Компани нь ТУЗ-өөс гаргасан шийдвэрийн дагуу 2019 онд Мөрөн сумын 100 жилийн ойд зориулсан номын үнэ 10,000.0 мянган төгрөгийг Хот тохижилт үйлчилгээний төв ХХК-руу шилжүүлсэн байна.

Аймгийн ИТХ, ТУЗ, гүйцэтгэх захирлын зүгээс гаргасан хөрөнгө зарцуулахтай холбоотой зарим шийдвэрүүд нь компанийн үр ашгийг бууруулсан байна.

Улсын төсвийн болон өөрийн хөрөнгө оруулалтаар Мөрөн хотын 13 гүний худаг, өөрийн хөрөнгөөр 2 гүний худагт ухаалаг систем суурилуулсан байна. Уг хөрөнгө оруулалт хийгдсэнээр иргэд хоногийн 24 цагийн аль ч цагт худгаар үйлчлүүлэх боломж бүрдсэн байна. Компанийн хувьд зардал хэмнэсэн үр өгөөжтэй арга хэмжээ болсон байна. Ухаалаг худгийн зардлын хэмнэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 9: мян.төг

Үзүүлэлт	Ухаалаг систем суурилуулахаас		Зөрүү
	Өмнө	Дараа	
Нийт орлого	56,709.4	75,947.6	19,238.1
Нийт зардал	60,963.4	33,863.2	-27,100.2
Нийт ашиг	(4,254.0)	42,084.4	46,338.3

Дээрх хүснэгтээс харахад гүний худагт ухаалаг систем суурилуулснаас өмнө нь 4,254.0 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан 15 гүний худгийн алдагдлыг 46,338.3 мянган төгрөгөөр бууруулж 42,084.4 мянган төгрөгийн ашигтай ажиллах болсон байна. Ухаалаг худаг төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалт, өөрийн хөрөнгөөр нийт 15 гүний худагт ухаалаг систем суурилуулсан нь компанид үр ашигтай хөрөнгө оруулалт болжээ. Цаашид бүх худгийг ухаалаг системд холбох нь эдийн засгийн болон хэрэглэгчдийн хувьд үр өгөөжтэй байна.

2.1.4 Гэр хорооллын ундны усны алдагдлыг нөхөх зорилгоор орон нутгийн төсвөөс авах татаасыг үндэслэлгүй тооцоолсон байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн үзүүлж байгаа үйлчилгээний нэг төрөл болох гэр хорооллын айл өрхүүдийн ундны цэвэр ус хангамжийн усан сангуудыг алдагдалгүй ажиллуулахад 2019 онд 462,141.3 мянган төгрөг, 2020 онд 532,527.8 мянган төгрөг шаардлагатай гэж тооцоолжээ. Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийн нэг болох 58.4.9¹⁴ дахь заалт, Засгийн газрын 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн тогтоолын дагуу усны үйлчилгээний төлбөрийг бууруулснаар үүсэх алдагдлыг Хөвсгөл аймгийн орон нутгийн төсвөөс 2019 онд 280,727.0 мянган төгрөг, 2020 онд 289,818.2 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Аудитаар 2020 оны усан сангийн усны алдагдлыг ерөнхий журналд бүртгэсний дагуу тооцож үзэхэд 290,627.6 алдагдалтай байна. Мөрөн сумын усан сангийн санхүүгийн тооцооллыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №10 мян.төг

Үзүүлэлт	Ус суваг ХХК төлөвлөж тооцоолсон дүн	Аудиторын тооцоолол	Зөрүү
Нийт орлогын дүн	218,198.80	83,307.00	134,891.80
Цалин	364,912.60	216,070.00	148,842.60

¹⁴ Усан хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж бий болгох, усны аж ахуйн хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх

НДШ	45,614.10	28,089.10	17,525.00
Цахилгаан	10,676.20	1,986.70	8,689.50
Түлш, халаалт	30,414.80	24,821.80	5,593.00
Шатахуун	64,680.00	44,990.80	19,689.20
сэлбэг	43,549.70	11,394.70	32,155.00
Засвар үйлчилгээ	16,477.20	12288.8	4,188.40
Элэгдэл	31,945.40	5,953.50	25,991.90
Бусад	110,257.80	8,920.30	101,337.50
Удирдлагын зардлаас усан санд ногдох хэсэг	32,198.80	19,418.90	12,779.90
Нийт зардлын дүн	750,726.60	373934.6	376,792.00
Шаардлагатай санхүүжилтийн дүн	532,527.80	290,627.60	241,900.20

Хөвсгөл ус суваг ХХК нь гэр хорооллын усан сангуудын үйл ажиллагааны алдагдалд 532,527.8 мянган төгрөгийн санхүүжилт авахаар тооцолж, төсвийн төсөл хүргүүлсэн нь үндэслэлгүй байна.

2.1.5 Хөвсгөл ус суваг ХХК өөрийн үйл ажиллагаанд ашигласан усны төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

“Хөвсгөл Ус суваг” ХХК нь 2020 оны байдлаар 202 аж ахуйн нэгж /ашиглагч 149, хэрэглэгч 53/, байгууллага, 45 орон сууц, 504 хувийн орон сууцны нийт 1831 айл өрхийг унд ахуйн цэвэр усаар ханган ажиллаж байна.

“Хөвсгөл Ус суваг” ХХК нь Усны тухай хуулийн 28.7 дах заалтын дагуу Байгаль орчин аялал жуулчлалын яамны 2018 оны 01 сарын 30-ны өдрийн 09а/678 тоот “Ус ашиглуулах дүгнэлт”, Дэлгэрмөрөн- Шишхэд голын сав газрын захиргааны 2018 оны 02 сарын 12-ны өдрийн 1/31 тоот зөвшөөрөл авч жилд 205,578.0 м3 ус ашиглах хэмжээг тогтоолгосон байна.

Ковид-19 тахлын улмаас аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаагүйгээс 2019-2020 онд үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлд борлуулсан усны хэмжээ буурсан байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хавсрал 4-оос харна уу

“Хөвсгөл ус суваг” ХХК нь 2019-2020 онд нийтийн халуун ус, дулаан хангамж, бусад туслах үйл ажиллагаанд үйлдвэр үйлчилгээний зориулалтаар 24,264 м3 ус ашигласан бөгөөд ус ашигласны төлбөр болох 2,198,318 / Хоёр сая нэг зуун ерэн найман мянга гурван зуун арван найман / төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь хууль тогтоомжид заасан үүргээ хэрэгжүүлээгүй, орон нутгийн төсвийн орлого дутуу бүрдэх үр дагавар бий болсон байна.

Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6.1 “Дор дурдсан зориулалтаар ашигласан ус, тэдгээрийн орчинд төлбөр ногдуулна, 6.1.1 “Хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус”, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад “ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усны төлбөрийг усаар хангагч байгууллага тооцож авна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна. Иймд аудитаар дээрх зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

2.1.6 Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний биелэлт 57 хувийн хэрэгжилттэй байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2019-2020 оны туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал. *Хүснэгт №11 /мян.төг/*

№	Туслах үйл ажиллагааны орлого	Төлөвлөгөө	Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
2019 он				
1	Түрээс	19,632.0	20,222.0	103%
2	Шинэ холболтын хураамж	2,000.0	2,043.0	102%
3	Засвар үйлчилгээ	10,000.0	5,634.0	56%
4	Машин механизмын орлого	12,000.0	4,961.0	41%
5	Усны тоолуурын үйлчилгээний орлого	6,000.0	3,178.6	53%
Нийт дүн		49,362.0	36,038.6	73%
2020 он				
1	Түрээс	19,632.0	14,568.0	74%
2	Шинэ холболтын хураамж	2,000.0	1,462.7	73%
3	Засвар үйлчилгээ	10,000.0	6,825.9	68%
4	Машин механизмын орлого	12,545.5	3,287.7	26%
5	Усны тоолуурын үйлчилгээний орлого	7,569.5	3,537.2	47%
Нийт дүн		51,747.0	29,681.0	57%

Хүснэгтээс харахад туслах үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл өмнөх оноос 6,357.6 мянган төгрөгөөр буурсан байна. Орлогын гүйцэтгэл буурахад түрээсийн орлого 5,634.0 мянган төгрөгөөр буурсан нь гол нөлөөг үзүүлсэн байна. Түрээсийн орлого буурсан нь Ковид-19 цар тахлын үеийн хорио цээрийн улмаас халуун ус, үсчин зэрэг үйлчилгээний газруудын үйл ажиллагааг зогсоосонтой холбоотой байна.

Бусад туслах үйл ажиллагааны орлогуудын төлөвлөгөө биелэгдээгүй байна. Эдгээр орлогууд нь хэрэглэгчдээс хүсэлт, дуудлага ирсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлж төлбөр авдаг тул төлөвлөгөөний гүйцэтгэл хангагдаагүй байна.

Цаашид туслах үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж, төлөвлөгөөг биелүүлж ажиллах шаардлагатай байна.

2.1.7 Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал алдаатай байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ний санхүүгийн алба нь 2019-2020 онуудад ерөнхий нягтлан бодогч, борлуулалтын нягтлан бодогч, ААНТБ орлого хариуцсан байцаагч, нярав, дотоод аудитор, тооцоо хариуцсан ажилтан гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр санхүүгийн үйл ажиллагааг эрхлэн явуулсан байна.

Тус компанийн 2019 оны санхүүгийн тайланд “Мөнгө Нөөц Баялаг Аудит” ХХК, 2020 оны санхүүгийн тайланд “Бизкон Аудит” ХХК тус тус аудит хийсэн байна.

Хөвсгөл ус суваг ХХК нь 2016-2020 оны хооронд нягтлан бодох бүртгэлдээ Виницца санхүүгийн программ ашиглаж байжээ. 2020 оны 06 дугаар сараас эхлэн Smart ERP санхүүгийн программыг ашиглан нягтлан бодох бүртгэлээ хөтөлж, санхүүгийн тайланг бэлтгэж байгаа боловч борлуулалтын орлого, зарлагаа MS Excel программ ашиглан бүртгэсэн нь тооцооллын алдаа гарах эрсдэлтэй байна. Мөн өндөр өртөгтэй санхүүгийн программыг бүрэн ашиглахгүй байна.

“Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,050,572.5 мянган төгрөгөөр буюу 118.3 хувиар өссөн

байна. Энэ нь Азийн хөгжлийн банкнаас авсан урт хугацаат зээлээр санхүүжиж байгаа 9 тэрбум төгрөгийн өртөгтэй цэвэрлэх байгууламж баригдаж байгаатай холбоотой байна.

2019 онд нийт өр төлбөрийн 20.6 хувийг богино хугацаат өр төлбөр, 79.4 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байсан бол 2020 онд нийт өр төлбөрт эзлэх богино хугацаат өр төлбөр 5.6 хувь болж буурсан байна. Харин урт хугацаат өр төлбөр 94.4 хувь болж өмнөх оноос 15 хувиар өссөн үзүүлэлтэй байна. 2019-2020 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн харьцуулалт: *Хүснэгт №12 /мян.төг/*

Үзүүлэлт	2019 оны үлдэгдэл	2020 оны үлдэгдэл	Өөрчлөлт өмнөх оноос	Хувь
Мөнгөн хөрөнгө	161,880.5	87,580.1	-74,300.4	-45.9
Авлага	213,635.1	389,363.5	175,728.4	82.2
Бараа материал	306,106.8	361,459.4	55,352.6	18.1
Үндсэн хөрөнгө	6,968,357.1	15,862,149.0	8,893,791.9	127.6
Нийт хөрөнгийн дүн	7,649,979.5	16,700,552.0	9,050,572.5	118.3
Богино хугацаат өр төлбөр	486,453.5	551,268.7	64,815.2	13.3
Урт хугацаат өр төлбөр	1,877,291.6	9,272,172.4	7,394,880.8	393.9
Цэвэр хөрөнгө	5,286,234.4	6,877,110.8	1,590,876.4	30.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,649,979.5	16,700,552.0	9,050,572.5	118.3

Эх сурвалж: 2019, 2020 оны санхүүгийн тайлан

Тус компанийн 2019-2020 оны санхүүгийн тайланг шалгаж үзэхэд дараах алдаанууд илэрлээ. **Үүнд:**

- Санхүү байдлын тайлангийн хөрөнгө, эх үүсвэрийн үлдэгдлийг э-тайлан болон аудит хийсэн тайланд зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь дуусаагүй барилга байгууламж данс болон урт хугацаат өр төлбөр данснуудын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасантай холбоотой байна.

Санхүүгийн тайлангийн зөрүүг харуулав. Хүснэгт №13 /мян.төг/

Үзүүлэлт	2019 оны үлдэгдэл	2020 оны үлдэгдэл /Э- Тайлан/	2020 оны үлдэгдэл /Аудит хийсэн тайлан/	Зөрүү
Дуусаагүй барилга	0	7,394,880.8	0	7,394,880.8
Бараа материал	306,106.8	361,459.3	7,398,880.8	-7,037,344.5
Урт хугацаат өр төлбөр	1,877,291.6	9,272,172.4	8,914,636.1	357,536.3

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дуусаагүй барилга байгууламж дансанд 7,394,880.8 мянган төгрөгөөр бүртгэх дүнг БМ-ын тодруулга тайлангийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд 7,037,344.5 мянган төгрөгөөр буруу бүртгэсэн байна.
- Зээлийн хүүгийн өглөг тооцоо нийлсэн актын дүнгээр 546,871.4 мянган төгрөг, санхүүгийн тайланд 475,910.5 мянган төгрөг. Зөрүү 70,960.9 мянган төгрөгөөр хүүгийн өглөгийг дутуу тайлагнасан байна. Энэ нь азийн хөгжлийн банктай цаг хугацаанд нь тооцоо нийлээгүйгээс шалтгаалсан байна.

Зээлийн хүүгийн өглөгийн үлдэгдэл:

Хүснэгт № 14: /мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /э- тайлан/	Аудит хийсэн тайлан	Тооцоо нийлсэн актын дүн	Зөрүү
----------	-------------------	-----------------------------------	------------------------	--------------------------------	-------

Зээлийн хүүгийн өглөг	475,910.5	475,910.5	475,910.5	546,871.4	70,960.9
------------------------------	-----------	-----------	-----------	-----------	----------

- Татварын өглөгийг татварын байгууллагатай тооцоо нийлээгүй дүнгээр бүртгэлд тусгасан зөрчил илэрсэн бөгөөд аудитын явцад татварын байгууллагатай тооцоо нийлсэн. Тооцоо нийлсэн актын дүн 73,290.6 мянган төгрөг, санхүүгийн тайланд тусгасан дүн 68,232.4 мянган төгрөг. Татварын өглөгийг 5,058.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

НӨАТ-н өглөгийн үлдэгдэл

Хүснэгт №15 /мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /э-тайлан/	Аудит хийсэн тайлан	Тооцоо нийлсэн актын дүн	Зөрүү
Татварын өглөг	1,965.1	68,232.4	68,232.4	73,290.6	5,058.2

- Үндсэн хөрөнгийн 2020 оны элэгдлийн зардлын дүн Э-тайланд 182,111.4 мянган төгрөг, аудит хийсэн санхүүгийн тайланд 187,537.7 мянган төгрөг, Ерөнхий журналаар 183,521.7 мянган төгрөг байна. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас 2020 онд ногдох элэгдлийг ШША-аар тооцож үзэхэд 191,859.9 мянган төгрөг байна.
- Үндсэн хөрөнгийн тайлан дахь хуримтлагдсан элэгдлийн зардлыг буруу тооцоолсон байна. /Жишээ нь: Барилга байгууламж дансны конторын барилгуудын хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг 18,090.6 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон алдаа байна/

Аудитаар 2020 оны үндсэн хөрөнгийн тайлангийн барилга байгууламж дансны эхний 8 хөрөнгийг жишээ болгон хуримтлагдсан элэгдлийг тооцоолсныг Хавсралт 5-аас харна уу.

Хөрөнгийн элэгдлийн буруу тооцоолол нь 2018.12.31-ний өдрөөрх дахин үнэлсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгэлд зөв тусгасан боловч цаашид ашиглах жил, ашиглалтад орсон огноог буруу бүртгэснээс шалтгаалсан байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ны санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн зөрүүг оруулаагүй дүнгээр 433,555.4 мянган төгрөгийн алдаа илэрсэн бөгөөд энэхүү алдаа нь СТОУС 1.27-29-д заасан үнэн зөв толилуулга, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 үнэн зөв байх гэсэн зарчим болон Үнэн зөв байдал / Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх/, Иж бүрэн байх / Аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх/ батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

Хөвсгөл ус суваг ХХК-ны 2019, 2020 оны санхүүгийн тайланд 433,555.4 мянган төгрөгийн алдаа илэрсэн бөгөөд буруу илэрхийлсэн үлдэгдлүүдийг залруулах зөвлөмж өгөх, мөн авлага, өглөгийг санхүүгийн тайланд тусгахдаа харилцагч байгууллага, иргэнтэй тооцоо нийлж, баталгаажуулж ажиллах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

2.2 Компанийн дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.2.1 Компанийн дотоод хяналтын үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байна

“Хөвсгөл ус суваг” ХХК нь Засгийн газрын 2013 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж, дотоод аудитын баг томилон ажиллуулж байгаа боловч үйл ажиллагаа нь хангалтгүй байна. Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө батлуулсан боловч, хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитор 2019 онд ТУЗ-өөс үндсэн орон тоонд томилсон боловч 2019, 2020 онд эдийн засагч, борлуулалтын нягтлан бодогчийн жирэмсний чөлөөтэй байх хугацаанд ажил үүргийг орлон гүйцэтгэж ирсэн байна. Дотоод аудиторын ажил үүргийн хуваарьт худалдан авах ажиллагааг оруулсан нь ашиг сонирхлын зөрчил үүсэх үр дагавартай байна.

ТУЗ-ийн аудитын хороо нь компанийн дотоод аудитын нэгжтэй ажлын уялдаа холбоогүй байна.

Компанийн ТУЗ болон байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагаа нь хангалтгүй байна.

2.2.2 Хяналт шалгалтын байгууллагын зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч ажилласан байна.

Аймгийн МХГ нь “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн цэвэр ус түгээх барилга байгууламж, тоног төхөөрөмжид төлөвлөгөөт болон улирал тутмын хяналтыг тогтмол хэрэгжүүлж ажилласан байна. Ундны хэрэгцээнд түгээж буй уснаас дээж авч аймгийн МХГ-ын дэргэдэх лабораторийн хими, нян судлалын шинжилгээнд хамруулсан байна.

Мөн бохир ус цэвэрлэх байгууламжийн бохир усны оролт, гаралтын цэвэрлэгдсэн бохир усны дээжид жил бүр шинжилгээ хийж ажилласан байна.

2018 онд ундны усны чанар аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсаар ус түгээх худаг, усан сан, зөөврийн машинуудад хяналт үнэлгээ хийж ажилласан байна. Хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээг хавсралт 6-с харна уу.

Бохир ус цэвэрлэх байгууламжийн бохир усны оролт, гаралтын цэвэрлэгдсэн бохир устай холбоотой зөрчлүүд нь 2021 онд ашиглалтад орсон шинэ цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа жигдэрснээр арилах боломжтой байна.

Хөвсгөл ус суваг ХХК нь аймгийн мэргэжлийн хяналтын газраас өгсөн Ковид-19 цар тахлын үеийн халдвар хамгааллын дэглэм баримтлах зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Цаашид шинэ цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг дулаан хангамж, үйлдвэрлэлд ашиглах боломжийг судалж шинэ технологи нэвтрүүлэх шаардлагатай байна.

2.2.3 Шилэн дансны мэдээллийг шинэчлээгүй байна.

Хөвсгөл ус суваг ХХК “Шилэн дансны тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1¹⁵, 3.1.1¹⁶, 6 дугаар зүйлийн 6.1¹⁷-д заасны дагуу мэдээлэл оруулах үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлэл оруулсан байдлыг хянаж үзэхэд 2019 онд 17 мэдээллийг хугацаа хоцроосон, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна. Шилэн дансны цахим хуудсанд 2020 онд 12 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Компанийн захирал, ерөнхий нягтлан бодогч солигдсон боловч удирдлагын мэдээллийг шинэчлээгүй байна. “Шилэн дансны тухай хууль”-д заасан мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлэх, удирдлагын мэдээллийг шинэчлэх шаардлагатай байна.

Аудитаар нийт 753.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс: 750.8 сая төгрөгийн зөрчилд 20 зөвлөмж, 1 албан шаардлага, 2.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

¹⁵ Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна

¹⁶ 3.1.1.төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

¹⁷ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ

ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хөвсгөл ус суваг ХХК-ийн бизнес төлөвлөгөөг үр нөлөөтэй байдлаар боловсруулаагүй, зорилтот түвшний төлөвлөлт, хэрэгжилтийг тайлагнахдаа орлого, зардлыг уялдуулаагүй, 2020 онд алдагдалтай ажилласан, нягтлан бодох бүртгэл, тайлагнал алдаатай, ТУЗ-ын дэргэдэх аудитын хороо болон компанийн дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй ажилласан байна.
2. Компанийн борлуулалтын орлого 2020 онд зорилтот түвшнээс буурч борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал өсөж, ашиг өмнөх оноос буурсан нь Ковид-19 цар тахал өвчний тархалтаас шалтгаалан хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарласан, нийтийн халуун усны үйл ажиллагааны алдагдал 271,626.1 мянган төгрөг байсантай холбоотой байна.
3. Ухаалаг худаг төслийг улсын төсвийн хөрөнгө оруулалт, өөрийн хөрөнгөөр нийт 15 гүний худагт ухаалаг систем суурилуулсан нь зардлыг хэмнэж, орлогыг өсгөсөн, хэрэглэгчдийн таашаалд нийцсэн компанид үр ашигтай хөрөнгө оруулалт болжээ.
4. Нийтийн халуун усны үйл ажиллагааны алдагдал нь компанийн нийт алдагдлын 96 хувийг эзэлж байгаагаас харахад халуун усны үйлчилгээний чанар хүртээмж, орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай болсон байна.
5. Аймгийн ИТХ, ТУЗ, гүйцэтгэх захирлын зүгээс гаргасан хөрөнгө зарцуулахтай холбоотой зарим шийдвэрүүд нь компанийн үр ашгийг бууруулсан байна.
6. Хөвсгөл ус суваг ХХК-нь 2020 оны нягтлан бодох бүртгэл тайлагнал алдаатай, авлага, өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн тооцоо зөрүүтэй байгаагаас харахад компанийн хөрөнгөд нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт алдагдсан байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:
“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн ТУЗ-д

1. Үйл ажиллагааны чиглэл буюу өртгийн төв бүрээр орлого, зардлыг уялдуулан зорилтот түвшнийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих
2. ТУЗ-өөс гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийг гаргаж байх, ТУЗ-ын ажлын тайланг ИТХ-д танилцуулж, үнэлэлт дүгнэлт авч байх
3. Компанийн хөрөнгийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах шийдвэр гаргах /дүгнэлтэй уялдуулах/
4. Компанийн дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх
5. Урт хугацаат зээлийг барагдуулах талаар салбарын яам, аймаг орон нутгийн удирдлагуудад хандаж шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах

“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн гүйцэтгэх захирал П.Лхагважавт

6. Компанийн зорилтот түвшнийг төлөвлөж, тайлагнахдаа үйл ажиллагааны чиглэл буюу өртгийн төв бүрээр орлого, зардал, ашгийг тооцож байх
7. Инженер, техникийн ажилтнууд, нягтлан бодогчид, эдийн засагчийн ажлын уялдааг сайжруулж, санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээ тайланг үнэн зөв гаргах
8. Халуун усны үйл ажиллагаа жил бүр алдагдалтай ажиллаж байгаад дүгнэлт хийж, борлуулалтын орлогод тавих дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, борлуулалт бүрд и-баримтыг олгож хэвших, шаардлагатай бол хувийн хэвшилд түрээслэх, менежментийн хувьчлалд оруулах асуудлуудыг судалж ИТХ, ТУЗ-өөр шийдвэрлүүлэх
9. Ерөнхий нягтлан бодогчийг давтан сургаж мэргэшсэн нягтлан бодогч болгож, зөрчлийг арилгах
10. Цаашид бүх худгийг ухаалаг системд холбох ажлыг зохион байгуулж ажиллах
11. Хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан олгож байх
12. Дотоод хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөг үр дүнтэй байхаар төлөвлөж, түүний дагуу бүрэн хэрэгжүүлж, тайлагнаж байх, худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийг дотоод аудитораас салгаж, өөр ажилтанд хариуцуулах
13. Туслах үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж, орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах
14. Ундны усны эх үүсвэрийн худгуудад цахилгааны нөөцийн эх үүсвэртэй болгох ажлыг зохион байгуулах

Эдийн засагчид

15. Үйл ажиллагааны чиглэл буюу өртгийн төв бүрээр орлого, зардлыг уялдуулан төлөвлөж, хэрэгжилтийг гаргаж байх

- 16.** Гэр хорооллын усан сангуудын үйл ажиллагааны алдагдлыг бодитой тооцон орон нутгийн төсвийн төсөлд хүргүүлж байх

Ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхзулд

- 17.** Цаашид санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаж байх, 2020 оны санхүүгийн тайланд гарсан авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой 433,555.4 мянган төгрөгийн алдааг 2021 оны санхүүгийн тайланд залруулах.
- 18.** Санхүүгийн тайланг гаргахаас өмнө харилцагч байгууллага иргэнтэй авлага, өр төлбөрийн тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх
- 19.** Үйл ажиллагааны чиглэл буюу өртгийн төвд нь тулгуурлан орлого зарлагыг үнэн зөв ангилан бүртгэж байх
- 20.** “Шилэн дансны тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтад хамаарах мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулж ажиллах, өөрийн байгууллагын шилэн дансны цахим хуудасны мэдээллийг шинэчлэх

Зөрчлийн жагсаалт

№	Аудитаар илэрсэн Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төг/	Өгсөн албан шаардлага		Төлбөрийн акт		Зөвлөмж	
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Компанийн зорилтот түвшнийг төлөвлөж, тайлагнахдаа үйл ажиллагааны чиглэл буюу өртгийн төв бүрээр орлого, зардал, ашгийг тооцож, батлаагүй байна.						4	
2	ТУЗ болон түүний дэргэдэх аудитын хороо үүргээ хангалттай хэрэгжүүлээгүй байна.						1	
3	ТУЗ нь Мөрөн сумын 100 жилийн ойд зориулсан ном худалдан авахтай холбоотой 10,000.0 мянган төгрөгийн үр ашиггүй шийдвэр гаргасан байна.	10.0					1	10.0
4	Компанийн дотоод хяналтын үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байна						1	
5	9,272,172.4 мянган төгрөгийн урт хугацаат зээлийн эргэн төлөх эх үүсвэр тодорхойгүй байна.						1	
6	Инженер, техникийн ажилтнууд, нягтлан бодогчид, эдийн засагчаас гарсан мэдээ тайлангууд хоорондоо зөрүүтэй байна.						1	
7	Компанийн 2020 оны халуун усны үйл ажиллагаа 271,626.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	271.6					1	271.6
8	Хөвсгөл ус суваг ХХК нь гэр хорооллын усан сангуудын үйл ажиллагааны алдагдлыг бодитой тооцоолж орон нутгийн төсвийн төсөлд хүргүүлээгүй байна.						1	
9	Ерөнхий нягтлан бодогч нь хууль дүрэмд заасан албан тушаалын шалгуурыг хангаагүй байна.						1	
10	Нягтлан бодох бүртгэлийн программыг бүрэн нэвтрүүлээгүй байхад төлбөрийг урьдчилж олгосон байна.						1	
11	Худалдан авах ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий дотоод аудитор нь худалдан авах ажиллагааг давхар хариуцан ажиллаж байна.						1	
12	Хөвсгөл ус суваг ХХК-ны 2019, 2020 оны санхүүгийн тайланд 433,555.4 мянган төгрөгийн алдаа илэрсэн.	433.5					2	433.5

13	Шилэн дансны мэдээлэл оруулсан байдлыг хянаж үзэхэд 2019 онд 17 мэдээллийг хугацаа хоцроосон, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна. 2020 онд 12 мэдээллийг хугацаа хоцроосон байна.						1	
14	Компани нь өөрийн дотоод хэрэглээ буюу нийтийн халуун ус, дулаан эрчим хүчээр хангах болон бусад үйл ажиллагаанд 2019-2020 онд 24,264 м3 ус ашигласны төлбөрт ногдох 2198.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төлөөгүй байна.	2.2			1	2.2		
15	Туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 2019-2020 онд 35,659.4 мянган төгрөгөөр тасарсан байна.	35.7					1	35.7
16	Авлага, өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулахгүй санхүүгийн тайланд тусгасан байна.		1					
17	Эх үүсвэрийн гүний худгууд нь цахилгааны нөөц эх үүсвэргүй байна.						1	
	Дүн	753.0	1		1	2.2	20	750.8

Хавсралт 1. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, гүйцэтгэл /мян.төг/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 он Гүйцэтгэл	2020 он Төлөвлөгөө	2020 он Гүйцэтгэл	Өмнөх оноос гүйцэтгэлийн өөрчлөлт	Биелэлт мөнгөн дүнгээр	биелэлт хувиар
Цэвэр ус	м.куб	162,620.6	201,235.0	190,570.0	57,949.4	10,665.0	94.7
Бохир ус	м.куб	160,050.4	209,926.0	199,430.0	39,379.6	10,496.0	95.0
Дулаан	ккал	236,592.0	279,656.0	274,062.0	37,470.0	5,594.0	98.0
Худаг, усан сан	м.куб	79,106.4	78,172.0	70,840.0	-8,266.4	7,332.0	90.6
НИЙТ ОРЛОГО	мян. төг	1,978,718.1	2,228,738.8	2,110,788.7	132,070.6	-117,950.1	94.7
Үүнээс: Үйл ажиллагааны орлого	мян. төг	1,697,990.8	1,948,011.8	1,820,970.5	122,979.7	-127,041.3	93.5
Усны алдагдлын татаас	мян. төг	280,727.3	280,727.0	289,818.2	9,090.9	9,091.2	103.2
НИЙТ ЗАРДАЛ	мян. төг	1,971,409.2	2,228,674.0	2,125,296.7	153,887.5	-103,377.3	95.4
Үүнээс ББӨ:	мян. төг	1,799,479.7	2,053,474.0	1,966,593.6	167,113.9	-86,880.4	95.8
Удирдлагын зардал	мян. төг	171,929.5	175,200.0	158,703.1	-13,226.4	-16,496.9	90.6
Татварын өмнөх ашиг	мян. төг	7,308.9	64.8	-14,508.0	-21,816.9	-14,572.8	
Цэвэр ашиг /алдагдал/	мян. төг	51,657.6	64.8	-14,508.0	-66,165.6	-14,572.8	
Борлуулалтын 1 төг-т ноогдох зардал	мян. төг	0.99	0.99	1.01			

Эх сурвалж: Хөвсгөл ус суваг ХХК-ий бизнес төлөвлөгөө, санхүүгийн аудитын тайлан

Хавсралт 2. “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн 2020 оны орлогын гүйцэтгэл /мян.төг/

Д.д	Орлогын төрөл	2020 оны төлөвлөгөө	2020 оны гүйцэтгэл		
			ТУЗ-д танилцуул сан	Борлуулалтын журналаар	Ерөнхий журналаар
1	ААН, байгууллагад нийлүүлсэн шугамын цэвэр ус	374,711.4	359,548.2	369,623.1	478,674.7
2	ААН, байгууллагад нийлүүлсэн шугамын бохир ус	355,454.7	362,953.7	358,599.7	533,435.3
3	ААН, байгууллагаас авсан усны суурь хураамж	28,733.5	27,770.2	28,422.2	57,912.9
4	ААН, байгууллагын халаалт	417,911.6	403,972.3	302,557.3	284,980.0
5	Орон сууцны халаалт	7,194.2	9,388.6		
6	Орон сууцны цэвэр ус	78,241.7	86,781.7	86,017.0	
7	Орон сууцны бохир ус	87,799.4	104,252.2	104,007.2	
8	Айл өрхөөс авсан усны суурь хураамж	26,431.2	28,022.4	27,723.6	
9	Зөөврийн цэвэр ус	13,386.8	8,802.3	11,498.2	
10	Зөөврийн бохир ус	33,524.3	30,574.1	45,702.7	
11	Халуун усны орлого	238,359.0	111,703.2	112,312.9	229,496.2
12	Худгийн орлого	123,734.2	126,459.3	77,014.3	129,216.1
13	Усан сангийн орлого	110,782.8	98,213.8	98,567.6	3,307.0
14	Түрээсийн орлого	19,632.0	14,568.0	5,177.0	4,438.8
15	Шинэ холболтын хураамж	2,000.0	1,462.7		
16	Слесарийн засвар үйлчилгээ	10,000.0	6,825.9		830.5
17	Машин механизмын орлого	12,545.5	3,287.7		

**“Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүн”
гүйцэтгэлийн аудитын тайлан**

ХӨА-2021/120-ШТА-ГА

18	Усны тоолуурын үйлчилгээ	7,569.5	3,537.2		670.0
19	Улсын татаас	280,727.3	280,727.3		289,818.2
20	Бусад			17,763.3	17,953.0
21	Гражийн орлого				56.1
	Дүн	2,228,739.1	2,068,850.8	Тодорхойгүй	2,110,788.8

Хавсралт 3: “Хөвсгөл ус суваг” ххк-ийн 2019-2020 оны цэвэр усны үйлдвэрлэл

№	Үйлдвэрлэлийн үзүүлэлт	Тоолууртай эсэх	Усны хэмжээ, м3	
			2019 он	2020 он
	Нийт олборлосон ус		331,982.0	325,606.6
	Шугам хоолойгоор орсон ус		255,123.0	262,992.0
1	Шугам хоолойгоор гарсан ус		254,055.0	247,737.0
	Үүнээс бичилт хийсэн цэвэр ус:		178,825.2	183,174.4
	ААН байгууллагад	тоолууртай	32,211.31	34,311.3
	Төсөвт газарт	тоолууртай	32,077.47	29,125.5
		тоолуургүй	57,828.5	49,684
	Орон сууц, айл өрх	тоолууртай	29,813.4	52,051.5
		тоолуургүй	3,295.8	2,452.1
	Хэрэглээний халуун ус		372.7	
	Технологийн хэрэгцээний ус /зууханд/		23226	15550
	Байгууллагын дотоод хэрэглээнд		12,132	12,132
	Усны алдагдал		63,097.82	52,430.60
2	Гэр хорооллын усан хангамж		77,927	77,869.63
	Үүнээс галын ус		365.0	0

Хавсралт 4: Дүгнэлтэд заасан усны хэрэглээ

/мян.төг/

Ангилал	Усны хэмжээ	Ус ашигласны төлбөр тооцох усны хэмжээ	Ус ашигласны төлбөрийн хэмжээ /жилээр/
Хэмжих нэгж	жилд м3	жилд м3	мянган төгрөг
Айл өрх /орон сууц, гэр хороолол	102509		
Төсөвт байгууллага	42855		Хэрэглэгч
Эрчим хүч /халаалтын зуух/	15508	15508	1,425.0
Аж ахуйн нэгж, байгууллага	44706	44706	4,050.0
НИЙТ	205578¹⁸	60214	5,475.0

Эх сурвалжийг “Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн 2017 оны мэдээлэлд үндэслэв: 1 м3 усанд ногдох төлбөрийн хэмжээг ЗГ-ын 302, 326, 327 тогтоолоор тогтоосон.

Хавсралт 5: Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоо

/мян.төг/

Нэр	Ашиглах жил	Ашиглаж эхлэх огноо	Эхний үлдэгдэл		Хуримтлагдсан элэгдэл	2020 оны Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл /Аудиторын тооцсон/	Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийн зөрүү
			Тоо хэмжээ	Өртөг	Эхний үлдэгдэл		
Конторын барилга	60	2009/12/31	1	26,590.2	443.1	4,431.7	3,988.5
Агуулах	60	2006/12/31	1	23,954.1	399.2	5,190.0	4,790.8

¹⁸ Усны тухай хуулийн 30.1.1.ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;¹⁸

Контторын урд талбай	10	2000/06/30	1	2,532.4	253.2	4,938.3	4,685.1
Контторын саад	25	2009/06/30	1	5,302.7	90.2	2,227.1	2,137.0
контторын хашаа	25	2000/09/30	1	1,121.0	44.8	863.1	818.3
Контторын сахиулын байр	60	2013/12/31	1	5,122.0	85.3	512.2	426.8
Сувиллын барилга	60	2006/03/01	1	5,816.1	96.9	1,340.9	1,244.0
Мод	15	2018/12/31	1	191.2	12.7	12.7	0.0
Дүн			8	70,629.9	1,425.6	19,516.3	18,090.6

Хавсралт 6: Мэргэжлийн хяналтын шалгалтаар илэрсэн зөрчлийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Илэрсэн зөрчил	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	Усны чанар аюулгүй аюулгүй байдалд үнэлгээ өгөх итгэмжлэгдсэн лаборатори байхгүй	2018 онд өөрийн итгэмжлэгдсэн лабораторийг ашиглалтад оруулсан
2	Худаг, усан сангуудад эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоосон хашаагүй	Худаг, усан сангуудын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг зөрчиж барилга байгууламж барьсны улмаас хашаажуулах боломжгүй байдал үүссэн байна
3	Худаг, усан сангийн барилга нь зориулалтын бус	Худаг усан сангийн барилгыг шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Одоогоо 6 сангийн барилгыг буулгаж шинээр барьсан байна.
4	Усан сангийн угаалга халдваргүйжүүлэлтийг тогтмол хийдэггүй	Усан сангийн халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж баримтжуулан ажиллаж байна
5	Ус түгээх сүлжээний усанд нян судлал, үлдэгдэл хлор, химийн бохирдлын үзүүлэлтээр шинжилгээ хийдэггүй	Өөрийн лабораториор шинжилгээг тогтмол хийж ажиллаж байна
6	Ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтээс гарсан, хүрээлэн буй орчинд нийлүүлж буй цэвэрлэгдсэн бохир ус нь шаардлага хангахгүй	Хуучин цэвэрлэх байгууламжаас гарч буй ус шаардлага хангадаггүй байсан бөгөөд 2021 онд ашиглалтад орсон шинэ цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа жигдэрснээр уг зөрчил арилах боломжтой байна.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 10 сарын 11 өдөр

№ 15/ААБСД468/ХӨА - 2021/120-ШТА-ГА Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Хөвсгөл ус суваг” ХХК нь 2019-2020 онд нийтийн халуун ус, дулаан хангамж, бусад туслах үйл ажиллагаанд үйлдвэр үйлчилгээний зориулалтаар 24,264 м3 ус ашигласан бөгөөд ус ашигласны төлбөр болох 2,198,318 / Хоёр сая нэг зуун ерэн найман мянга гурван зуун арван найман / төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь хууль тогтоомжид заасан үүргээ хэрэгжүүлээгүй, орон нутгийн төсвийн орлого дутуу бүрдэх үр дагавар бий болсон байна.

Энэ нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6.1 “Дор дурдсан зориулалтаар ашигласан ус, тэдгээрийн орчинд төлбөр ногдуулна, 6.1.1 “Хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус”, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад “ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усны төлбөрийг усаар хангагч байгууллага тооцож авна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.4 “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Хөвсгөл ус суваг” ХХК-ийн 2019-2020 онд үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ус ашигласны төлбөрийн төлөөгүй дүн 2,198,318 /Хоёр сая нэг зуун ерэн найман мянга гурван зуун арван найман/ төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл ус суваг ХХК-ийн захирал П.Лхагважав, ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхзул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:
АХЛАХ АУДИТОР

О.ГАНБОЛД
Д.ОТГОНБАЯР

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 307, тоот Утас:70384043

Аудитаар өгсөн албан шаардлага



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 10 сарын 11 өдөр

№ 26/A2270440/2021 - 2021/120-ШТА-ГА Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хөвсгөл ус суваг ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Хөвсгөл ус суваг ХХК нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд авлага, өр төлбөрийн дүнг тусгахдаа харилцагч байгууллага, иргэдтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”-ийн, 12.2.1 дахь “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” заалтуудтай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7 “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй”-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хягас жил болон жилийн эцсийн санхүүгийн тайланд авлага, өглөгийн дүнг тусгахдаа харилцагч байгууллага, иргэдтэй тооцоо нийлж, баталгаажуулан ажиллаж, биелэлтийг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэх,

2. Цаашид дээрх алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөвсгөл ус суваг ХХК-ийн захирал П.Лхагважав, ерөнхий нягтлан бодогч Б.Мөнхзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



О.ГАНБОЛД
Д.ОТГОНБАЯР
Л.МАНДАХНАРАН

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043

Хөвсгөл аймгийн ИТХ-аас тайлангийн төсөлд ирүүлсэн санал



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРАЛ**

67120. Хөвсгөл аймаг, Мөрөн сум
Нутгийн удирдлагын ордон 3 давхар. Утас: 7038 2764,
Факс: 7038 2554 Э-мэйл: aimginithural@khs.gov.mn
Вэбсайт: Khovsgol.Khural.mn

2021.10.22 № 01/190
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

“Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөс дараах саналыг хүргүүлж байна.

- 1.Үе үеийн дарга нарын ажлаас шалтгаалах зүйл алга.
- 2.Хамгийн гол нь онцгой объектийн байгууллага.Тайлангаас харахад тус компанийн татвар, шимтгэл, цалингийн зардалд нийт зардлын 72 хувь эзэлж байгаа нь цаг үеийн шаардлагаар техник технологийн шинэчлэл хийж ажиллах шаардлагатайг харуулж байна.
- 3.Усан сангуудаа smart болгох
- 4.Халуун усаа менежмент хувьчлалд оруулах
- 5.Цэвэр ус бохирын шугамаа тоолуурт шилжүүлэх, ингэснээр ашигтай ажиллаж 378 сая төгрөгийн татаас авахгүй ажиллана
6. Цалин, татварын зардал 50 хувиар буурна. Ашигтай ажиллана.

ДАРГА

Г.МӨНГӨНХУЯГ

Санал 2
тайлангийн
төсөлд туссан
тул өөрчлөлт
оруулаагүй.

Санал 3-ыг
хүлээн авч
тайланд
өөрчлөлт
оруулсан.

Санал 4-ийг
хүлээн авч
тайланд
өөрчлөлт
оруулсан.

Санал 1, 5, 6-г
тайлбар гэж
үзэж тайланд
өөрчлөлт
оруулаагүй

“Хөвсгөл ус суваг” ХХК-аа тайлангийн төсөлд ирүүлсэн санал



“ХӨВСГӨЛ УС СУВАГ”
ХХК

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг.

Чингүнжавын талбайн урд

Утас, факс: 7038-3099

И-Мэйл: khuvsgul_us.suvag@gmail.com

2021. 10. 20 № 176

Танай


№

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР-Т

Манай компанийн 2019-2020 оны үйл
ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцаж санал хүргүүллээ.

Хавсралт 3 хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  П.ЛХАГВАЖАВ



**“Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны үр дүн”
гүйцэтгэлийн аудитын тайлан**

ХӨА-2021/120-ШТА-ГА

"Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн
2021 оны 10-р сарын 20-ний
өдрийн №176 тоотын хавсралт

"Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх санал

2021.10.20

№	Аудитаар илэрсэн		Тайлангийн төсөлд өгөх санал
	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төг/	
1	ТУЗ нь хөрөнгийг зарцуулахтай холбоотой 21,300.0 мянган төгрөгийн үр ашиггүй шийдвэр гаргасан байна.	21.3	21,300.0 мянган төгрөгийг хэзээ, ямар үйл ажиллагаанд үр ашиггүй зарцуулсан талаар тодорхой тусгаж өгөх.
2	Компанийн 2020 оны халуун усны үйл ажиллагаа 271,626.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.		Энэ талаар асуудлын бүртгэл дээр саналаа тусгасан. Нийт 3 халуун усны газраас хамгийн их алдагдалтай ажиллаж байсан 2-р халуун усыг 2020 оны 10- сард, 3-р халуун усыг 2021 оны 7-р сард дуудлага худалдаагаар оруулж худалдаалсан. Үлдсэн 1-р халуун усанд их засвар хийн, шугам шүлжээг шинэчилж үнэ тарифт өөрчлөлт оруулсан ба халуун усны орлого өмнөх оноос өсөх хандлагатай байна.
3	Шилэн дансны мэдээлэл оруулсан байдлыг хянаж үзэхэд 2019 онд 17 мэдээллийг хугацаа хоцороосон, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй бн. 2020 онд 12 мэдээллийг хугацаа хоцороосон, мөн худалдан авах ажиллагааны тайлаз мэдээлээгүй байна.		Шилэн дансанд худалдан авах ажиллагааны 2019, 2020 оны тайланг оруулсан. Тайланг хэвлэж хүргүүлэв.
4	Компани нь өөрийн дотоод хэрэглээ буюу нийтийн халуун ус, дулаан эрчим хүчээр хангах болон бусад үйл ажиллагаанд 2019-2020 онд 24,264 м3 ус ашигласны төлбөрт ногдох 2198.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төлөөгүй байна.	2.2	Ковид-19 цар тахлын улмаас 2020 он, 2021 оны эхээр нийтийн халуун ус ажиллахгүй байсан мөн төсөвт газрууд буюу сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа явагдахгүй байсантай холбоотой эдгээр байгууллагуудаас орох орлого тасарсан зэрэг шалтгааны улмаас уг төлбөрийг төлөх боломжгүй байна. 2022 онд дотоод хэрэглээний ус ашигласны төлбөрийг бизнес төлөвлөгөөндөө тусган цаг хугацаанд нь төлнө.
5	Эх үүсвэрийн гүний худгууд нь цахилгааны нөөц эх үүсвэргүй байна.		2021 онд эх үүсвэрийн гүний худгуудын цахилгааны нөөц эх үүсвэртэй болох төндөр 3 удаа зарласан боловч оролцох компани байхгүй хойшлогдсон. Одоо техникийн нөхцөл, үзүүлэлтээ өөрчлөн дахин төндөр зарласан ба сонгон шалгаруулах шатанд явж байна.

Жич: Бусад зөвлөмж, зөрчлийг судлан авч үзэж зөрчлийг арилгах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Санал 1-ийг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан.

Санал 2-ийг хүлээн авч тайланд тусгасан.

Санал 3-ыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан.

Санал 4-ийг хүлээн авах боломжгүй гэж үзлээ.

Санал 5-ыг тайлбар гэж үзэж тайланд өөрчлөлт оруулаагүй